# ГОЛОМТ БАНК ХК

**2025 оны жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан**

**Аудитлагдаагүй санхүүгийн үр дүн**

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## НҮҮРСНИЙ ЭКСПОРТ: ТОО ХЭМЖЭЭ
сая тонн




Эх сурвалж: ҮСХ

## ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ
2025 оны байдлаар
сая ам.доллар




Эх сурвалж: Монголбанк

## ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ

**+65.7**

Сая ам.доллар
2025 оны 11-р сар

Эх сурвалж: Монголбанк

## ГВАН
сая ам.доллар




Эх сурвалж: Монголбанк

## ВАЛЮТЫН ХАНШ
(төгрөг/ам.доллар)




Эх сурвалж: Монголбанк

## ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ
жилийн өсөлт




Эх сурвалж: ҮСХ



## БОДЛОГЫН ХҮҮ

**12%**

Мөнгөний бодлогын хороо 2025 оны 12 дугаар сард бодлогын хүүг 12 хувьд өөрчлөлтгүй **хадгалах шийдвэр гаргасан** бөгөөд 2025 оны 3 дугаар сараас эхэлсэн хатуу мөнгөний бодлогын чиглэлийг хэвээр үргэлжлүүлэв.

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ҮНДЭСНИЙ ИНФЛЯЦ БОЛОН БОДЛОГЫН ХҮҮ




Эх сурвалж: Монголбанк

MONGOLBANK
CENTRAL BANK OF MONGOLIA

### 2025 оны 12-р сарын 11

- Мөнгөний бодлогын хороо бодлогын хүүг 12%-ийн түвшинд хэвээр үлдээв.

### 2026 оны 1-р сарын 16

- Шинэ болон дахин бүтэцжүүлсэн хэрэглээний зээлд мөрдөгдөх өр орлогын харьцааны дээд хязгаарыг 45%-иар тогтоов.
- Заавал байлгах нөөцийг 1 суурь нэгжээр нэмэгдүүлж, дотоод валютын хувьд 14%, гадаад валютын хувьд 19% болгон тогтоолоо.

# МАКРО - ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТААМАГЛАЛ




Эх сурвалж: Монголбанк, ОУВС, Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк

### 2025 оны гүйцэтгэл:

- Таатай уур амьсгалын үр дүнд малын хэвийн бус хорогдлыг түүхэн доод түвшинд хадгалснаар хөдөө аж ахуйн салбар 2025 онд эдийн засгийн өсөлтийн гол тулгуур болж чадлаа.
- 2025 оны хоёрдугаар хагаст уул уурхайн салбар эдийн засгийн өсөлтөд хүчтэй дэмжлэг үзүүлэв. Нүүрсний үнэ өмнөх онтой харьцуулахад буурсан хэдий ч экспортын биет хэмжээ огцом нэмэгдсэнээр олборлолтын хэмжээ сэргэж, салбарын гүйцэтгэл сайжрав. Түүнчлэн Оюу Толгойн далд уурхайн олборлолт эрчимжиж, зэс болон алтны агуулга нэмэгдсэнтэй зэрэгцэн олон улсын зах зээл дээрх үнийн өсөлт уул уурхайн нийт үйлдвэрлэлийг цаашид хүчтэй дэмжсэн юм.

### 2026 оны хүлээлт:

- Уул уурхайн салбарын өсөлт цаашид ч хүчтэй хэвээр хадгалагдах төлөвтэй бөгөөд үүнд Оюу Толгойн зэсийн олборлолт болон нүүрсний экспортын хэмжээ өсөх хүлээлт голлон нөлөөлж байна.
- Засгийн газрын хэрэгжүүлж буй мега төслүүд нь барилга, эрчим хүч, худалдаа зэрэг бусад салбарын өсөлтийг дэмжих төлөвтэй байгаа бол хөдөө аж ахуйн салбарын өсөлт тогтворжих хандлагатай байна..

**Австрали коксжих нүүрс, ам.доллар/тонн**




**Зэсийн хилийн үнэ, ам.доллар/тонн**




**Алтны хилийн үнэ, ам.доллар/унц**




Эх сурвалж: Блүүмберг терминал

ГОЛОМТ БАНК

# IV УЛИРЛЫН ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

# ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА, САНХҮҮЖИЛТ



**230 САЯ ДОЛЛАР**

Cargill | symbiotics | IFC International Finance Corporation World Bank Group | Triple Jump
SAISON Investment Management | BlueOrchard Impact Investment Managers | PROPARCO Groupe AFD | atlantic forfaitierungs ag

## САМУРАЙ БОНД



SMBC | SMBC NIKKO

| ХУГАЦАА | ӨГӨӨЖ |
|---|---|
| **3 жил** | **1.85%** |

ДҮН
**JPY 15 ТЭРБУМ**

Энэхүү хэлцэл нь Монгол төдийгүй Азид шинэ жишгийг тогтоон Монголын банк, санхүүгийн байгууллагуудын санхүүжилтийн **эх үүсвэрийг төрөлжүүлж**, цаашид Японы зах зээлд өргөжин тэлэхэд нь дэмжлэг болсон бөгөөд Япон улсын нийт **30 гаруй мэргэжлийн хөрөнгө оруулагчдыг** амжилттай татсан. Самурай бондоор татсан хөрөнгө оруулалт нь Монгол Улсад хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх, бизнес эрхлэгч нарт төрөл бүрийн зээлийн үйлчилгээгээр дамжин хүрэх юм.

European Bank for Reconstruction and Development

Голомт банк ЕСБХБ-тай 20 сая ам.долларын зээл, худалдааны санхүүжилтийн гэрээ байгууллаа. Энэхүү санхүүжилт нь ЕСБХБ-ны “Төв Азийн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих хөтөлбөр” болон “Залуу бизнес эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд бизнес эрхлэгчдэд олгогдоно.



# ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

BACK TO THE FUTURE BUSINESS CONFERENCE 2025

**6 ДАХЬ ЖИЛДЭЭ**




Голомт банкны хувьд жижиг, дунд бизнесийг дэмжих чиглэлээр төрөл бүрийн төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх, санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэхэд онцгой анхааран ажиллаж ирсэн. Энэ хүрээнд Business Conference арга хэмжээг тасралтгүй 6 жил зохион байгуулж, нийт 500 гаруй байгууллагын төлөөлөл, удирдлагууд хүрэлцэн ирж, оролцлоо.

FMC FINANCIAL MANAGERS' CONVENTION 2025 BACK TO THE FUTURE

**7 ДАХЬ ЖИЛДЭЭ**




Бид 2019 оноос хойш нийт 2600 гаруй санхүүгийн менежер, удирдлагуудыг энэхүү арга хэмжээнд хамруулсан байна. Дэлхийн ирээдүйн хөгжил болон эдийн засаг, бизнесийн салбарын дэвшил хиймэл оюун ухаанаас шууд хамаарах нь тодорхой боллоо. Тиймээс энэ удаагийн арга хэмжээнд ирээдүйн бизнесийн чигийг өөрчлөх AI суурьтай технологийн шийдлүүдийг бид хэрхэн оновчтой ашиглаж, удирдаж болох талаар илтгэл, мэдээллүүдийг түлхүү хүргэхийг зорилоо.

# ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ
















**“OPENMINDMSE:**

Монголын ХЗЗ сонин хачин” 2700 гаруй гишүүнтэй арилжаа эрхлэгч, хувьцаа эзэмшигчдийн группт улирал бүр earnings call зохион байгуулж байна



# ДИЖИТАЛ БАНК




Google wallet-д голомт банкны мастер карт, т-брендийн картаа холбон ашигладаг боллоо.

Google Pay бол дэлхийн олон оронд идэвхтэй ашиглагддаг, 700 сая гаруй хэрэглэгчтэй дижитал төлбөрийн хэтэвч юм. Монгол улсад давхардсан тоогоор 2.6 сая андройд хэрэглэгчид байна.

Голомт банк санхүүгийн салбарт дэлхийн дэвшилтэт технологийг түүчээлэн нэвтрүүлэгчийн хувьд Google компанитай хамтран Google Pay төлбөрийн хэрэгслийг Монгол Улсад албан ёсоор нэвтрүүлж, төлбөрийн шинэ шийдлийг харилцагчдадаа санал болгож байна. Ингэснээр Голомт банкны карт эзэмшигчид Android болон Wear OS төхөөрөмжөөр дэлхийн аль ч улс оронд NFC тэмдэглэгээ бүхий ПОС дээр, гар утсаараа хормын дотор төлбөр тооцоо хийх боломж бүрдлээ

# ДИЖИТАЛ БАНК




SocialPay ашиглан WeChat QR кодыг уншуулж, UnionPay картаараа БНХАУ-д төлбөр тооцоогоо саадгүй хийх боломжтой боллоо. Ингэснээр нэмэлт шимтгэлгүйгээр бүхий л худалдаа үйлчилгээний газруудад ашиглах боломжтой ОУ-н төлбөрийн шийдлийг нэвтрүүллээ.



# ДИЖИТАЛ БАНК




Голомт банкны 66 салбарт шинэ киоск төхөөрөмжийг байршуулан, салбарт хийгдэх 30 орчим үйлчилгээг киоск руу шилжүүллээ. Салбарын онлайн бүртгэлийн системийг нэвтрүүллээ.

Салбарын дугаар дуудагчийг бүх салбарт шинэчлэн нэвтрүүлснээр харилагчид салбарт ирэхээс өмнө зайнаас дугаараа захиалах боломжтой боллоо.

Голомт банкны зарим салбаруудад (5 салбар) дебит картуудыг газар дээр нь хэвлэх боломжтой болсноор, картын үйлчилгээ харилцагчид улам бүр ойртлоо.

# ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Голомт банкны хамт олон 30 жилийнхээ ойг тохиолдуулан картын загвараа бүрэн шинэчилж, хил хязгааргүй орон зай, цаг хугацааг илэрхийлэх Universe шинэ картуудаа танилцуулж байна. Universe загварын картууд нь санхүүгийн ертөнцийг таны гарт атгуулж, огторгуйн өргөн уудамд эргэлдэгч дагуул адил дэлхийн хаана ч таны санхүүгийн аяллын хөтөч болж, хил хязгааргүй боломж, дахин давтагдашгүй үнэ цэн, нэр хүндийн баталгааг өгөх болно.

Голомт банк Монголын хамгийн анхны wearable карт буюу зайнаас унших технологи бүхий төлбөр тооцооны моделийг хэрэглээнд нэвтрүүллээ. Энэ бол 7-22 насны хүүхэд, залуучуудад зориулсан SKATE CARD юм. Skate card нь банкны картын мэдээллийг суулгасан skateboard модель гэдгээрээ энгийн төлбөрийн картаас ялгаатай бөгөөд NFC технологийг ашиглан бүх төрлийн ПОС төхөөрөмж дээр уншихаас гадна И-коммерс дээр онлайнаар худалдан авалт хийх боломжтой төлбөрийн хэрэгсэл юм.



# ШИНЭЛЭГ КАРТ



# НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА




**“Өв соёлын голомт” төслийн Хар толгой болон Ингэт толгойн судалгааг “Оны шилдэг” археологийн судалгаагаар нэрлэлээ**
“Монголын археологи” эрдэм шинжилгээ, судалгааны тайлангийн хүрээнд эрдэмтдийн санал хураалтаар 5 судалгааны ажлыг “ОНЫ ШИЛДЭГ”-ээр шалгаруулан Голомт банкнаас санаачлан хэрэгжүүлж буй “Өв соёлын голомт” төслийн хүрээнд Булган аймгийн Хар толгой болон Ингэт толгойн дурсгалт газарт хийсэн археологийн малтлага судалгааны ажил Тэргүүн байр эзэлж, оны шилдэг судалгаагаар нэрлэгдлээ.




**Голомт банк “Алтны форум-2025” арга хэмжээний хандивыг “Зүрх мартахгүй” төсөлд гардууллаа**
Бид 2020 оноос хойш энэхүү төслийн албан ёсны түншээр хамтран ажиллаж байгаа бөгөөд “Алтантулхүүр” хүүхдийн сангаар дамжуулан санхүүгийн болон бусад дэмжлэгийг тууштай үзүүлж, энэ хугацаанд нийт 450 сая төгрөгийн дэмжлэг олгоод байна. Харин энэ жилийн “Алтны форум” арга хэмжээний дуудлага худалдаанд “Уулс Ноён” ХХК-ийн Гүйцэтгэх захирал П.Энхтулга ялагч болж, “Зүрх мартахгүй” төсөлд 90 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олголоо.



**Хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдийг дэмжихэд Голомт банк хамтран ажиллана**
Голомт банк хөгжлийн бэрхшээлтэй бизнес эрхлэгчдийг чадавхжуулах, тэдэнд санхүүгийн боловсрол олгох зорилгоор “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэгш хүртээмж итгэл” ТББ-тай хамтран ажиллах санамж бичгийг Equality for all” арга хэмжээний үеэр зурсан юм. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бизнес эрхлэгчдийг дэмжигч байгууллагад олгодог хамгийн хүндэтгэлтэй шагнал болох “Итгэлийн од” шагналыг хүртээсэн бөгөөд Голомт банк уг шагналын анхны эзэн боллоо.



**Голомт банк “Оны онцлох хүүхэд” арга хэмжээг дэмжин ажиллаа**
Эх орны ирээдүй болсон хүүхэд, багачуудын сайн сайхан амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлэх, тэдний ирээдүйд хөрөнгө оруулах санал санаачилгыг онцгойлон дэмжин Голомт банк “Оны онцлох хүүхэд” арга хэмжээнд хамтран ажиллаж, онцгой амжилт гарган үе тэнгийнхнээ манлайлсан шилдэг хүүхдүүдийг Алтантулхүүр хүүхдийн хадгаламжийн эрхээр урамшуулж, тэдний ирээдүйд хуримтлалтай, санхүүгийн дархлаатай иргэн болон төлөвшихөд нь хувь нэмрээ оруулаа.

## ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

ТЭРБУМ МОД ҮНДЭСНИЙ ХӨДӨЛГӨӨН

“Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг дэмжих сан”-г банк хоорондын төлбөр тооцооны үйл ажиллагаагаар дэмжин ажиллаж байна.

**₮ 1.2 тэрбум**
2025Q4

## ГОЛОМТ БАНК БА AI ACADEMY ASIA

**Үр дүн**

| 100 | 100 |
|---|---|
| ЕБС багш нар | 13-18 насны сурагчид |




Алслагдсан аймаг, дүүргийн сурагчдыг тэгш хамруулахыг зорьсон уг хөтөлбөрт Монгол Улсын 21 аймаг, нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын сургуулиудын 2000 гаруй багш, сурагчаас шалгарсан 100 багш, 13-18 насны 100 сурагч хамрагдлаа. 2024 оны 10-р сард хөтөлбөр нээлтээ хийж, хоёр сар гаруйн хугацаанд оролцогчид эрчимжүүлсэн сургалтаар дамжуулан хиймэл оюуны үндэс, Python програмчлал, өгөгдөл боловсруулах аргачлал, хэлний загварчлал, машин сургалт, Vibe coding, AI ethics зэрэг сэдвүүдийг судалсан.

## АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ЧИГЛЭЛД ЧДЗДТГ-ТАЙ ХАМТРАН АЖИЛЛАА







Голомт Банк нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн зорилтын хүрээнд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн агаарын бохирдол өндөртэй бүсэд амьдардаг 300 айл өрхийн зуухыг эрчим хүчний өндөр хэмнэлтэд агаар-агаарын дулааны насосоор солих ажлыг санхүүжүүллээ.

# ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

| Агентлаг | Үнэлгээ |
| --- | --- |
| S&P Global Ratings | **B+ Positive**<br>▲B+ stable<br>2025-10-31 |
| Fitch Ratings | **B+ Stable** |
| MOODY'S RATINGS | **B1 Stable**<br>▲B2 stable<br>2025-10-20 |

Great Place To Work. Certified Nov 2022- Nov 2023 MONGOLIA

Great Place To Work. Certified Nov 2023- Nov 2024 MONGOLIA

Great Place To Work. Certified Nov 2024- Nov 2025 MONGOLIA

Great Place To Work. Certified Nov 2025- Nov 2026 MONGOLIA

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн
**АЖИЛЛАХАД ТААТАЙ ГАЗАР**-аар
дөрөв дэх жилдээ батламжлагдлаа

| Ази | Монгол | Голомт банк |
| --- | --- | --- |
| 90% | 82% | 91% |

EUROMONEY AWARDS FOR EXCELLENCE 2025
MONGOLIA
BEST BANK FOR SMES




GOLOMT BANK | BNY

ГОЛОМТ БАНК ГАДААД ТӨЛБӨР ТООЦООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРААРАА THE BANK OF NEW YORK MELLON (BNY) БАНКНЫ ШАГНАЛЫГ ХҮРТЛЭЭ

ГОЛОМТ БАНК

Голомт банк 2025 оны Тогтвортой хөгжилд манлайлагч **Шилдэг ТоС банк**-аар тодорлоо



# ҮНЭТ ЦААСНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

## MSE:GLMT Хувьцаа

Хоёрдогч зах зээлийн хувьцааны ханш




## SGX:GLMTMO27 Бонд

Хоёрдогч зах зээлийн бондын ханш



ГОЛОМТ БАНК

# IV УЛИРЛЫН САНХҮҮ ҮР ДҮН

# САНХҮҮ ҮР ДҮН




**Нийт хөрөнгө** ▲23.0%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29% (2022-2025)




**Нийт зээл** ▲11.0%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 29%




**Татан төвлөрүүлсэн хөрөнгө** ▲23.0%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 30%



# ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

**Нийт зээлийн бүтээгдэхүүн** ▲11.0%
/тэрбум төгрөг/




**Хэрэглээний зээл** ▼3.3%
/тэрбум төгрөг/




**Орон сууцны зээл** ▲12.7%
/тэрбум төгрөг/




**Бизнесийн зээл** ▲17.6%
/тэрбум төгрөг/




**Зээлийн багцын задаргаа**
/хувь/



# ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

**Өөрийн хөрөнгийн хүрэлцээ (%)**




**Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар (%)**




**Гадаад валютын эрсдэлийн харьцаа (%)**




**Холбоотой этгээдэд олгосон зээл**




**Чанаргүй зээлийн сангийн хүрэлцээ (%)**




**Чанаргүй зээлийн харьцаа (%)**



# САНХҮҮ ҮР ДҮН

- Харилцагч төвтэй бодлого, оновчтой шийдвэр гаргалт, өгөгдөлд суурилсан удирдлагын тогтолцооны үр дүнд Голомт банк 2025 онд нийт хөрөнгөө 23 хувиар өсгөн, 19 их наяд төгрөгт хүргэж, салбарын нийт хөрөнгийн 22.3 хувийг бүрдүүлж байна.
- 2025 онд нийт зээлийн багц өмнөх онтой харьцуулахад 805.2 тэрбум төгрөг буюу 10.8%-аар тэлж, 8.3 их наяд төгрөгт хүрлээ. Зээлийн багцын өсөлтөд ЖДБ-ийн зээлийн багц голлон нөлөөлж, 27.4 хувиар буюу 484 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн.
- Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд чиглэсэн зээлийн бодлогоо эрчимжүүлж, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ эрсдэлийн удирдлагыг сайжруулсны үр дүнд активын чанар сайжирч, чанаргүй зээлийн харьцаа 2.5 хувь болж буурсан нь банкны салбарт тэргүүлэх үзүүлэлт боллоо. Түүнчлэн зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээ 101.7 хувьд хүрч, санхүүгийн сахилга бат, хариуцлагатай удирдлагын тогтолцоог олон улсын жишигт нийцүүлж ажиллаа.
- Нийт татан төвлөрүүлсэн хөрөнгө 3.2 их наяд төгрөгөөр буюу 23.1 хувиар өсгөн 17 их наяд төгрөгт хүрэв. Гадаад түншлэлээ өргөжүүлэх хүрээнд банк 2025 онд жилийн 8%-ийн хүүтэй 50 сая ам.долларын ногоон болон нийгмийн чиглэлийн бонд, мөн 3 жилийн хугацаатай, 15 тэрбум иений Самурай бондыг амжилттай гаргалаа.
- Үүнээс гадна олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас нийт 169.5 сая ам.долларын эх үүсвэр татсанаар банкны санхүүжилтийн бааз суурь бэхжиж, үйл ажиллагааны цар хүрээ мэдэгдэхүйц өргөжив.
- 2025 онд Голомт банк 345.1 тэрбум татварын дараах цэвэр ашигтай ажиллаж, тайлант хугацаанд дундаж өөрийн хөрөнгийн өгөөж 24.3%-д хүрсэн байна.
- Монголбанк болон олон улсын хөрөнгө оруулагчдын тавьдаг зохистой байдлын гол шалгуур үзүүлэлтүүдийг шаардлагаас давсан түвшинд тогтвортой ханган ажиллаж буй нь банкны санхүүгийн тогтвортой байдлыг баталгаж байна.

**Цэвэр ашиг**
/тэрбум төгрөг/




**Өөрийн хөрөнгө** ▲23.0%
/тэрбум төгрөг/
ЖДӨХ: 23%




**Дундаж өгөөж (%)**



# БАЯРЛАЛАА

https://www.golomtbank.com/investor-relations

investornews@golomtbank.com

1800-1646